



БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Л. ЭРХБААТАР

**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК**

**“БЭН №2, 4 НАСОС ДЭЭР ДАВТАМЖ ХУВЬСГУУР ТАВИХ” АЖИЛ  
ГҮЙЦЭТГЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**ОРХОН АЙМАГ**

**2020 ОН**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ЭДЦС” ТӨХК нь сонирхсон эрх бүхий оролцогчдоос **“БЭН №2, 4 НАСОС ДЭЭР ДАВТАМЖ ХУВЬСГУУР ТАВИХ /2 ш/”** ажил гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн *саналыг* 2020 оны 9-р сарын 02-ний, 09:00 цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны WWW.TENDER.GOV.MN цахим системээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан (“ЭДЦС” ТӨХК 4 давхар 406 тоот өрөө) 2020 оны 9-р сарын 02-ний 09:30 цагт цахимаар нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймаг, Баян өндөр сум, Баянцагаан баг “ЭДЦС” ТӨХК-ийн 4 давхар, 406 тоот өрөө Г. Энхтуул, утас 99078384, Факс 70353718.**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) ТШӨХ-д заасан бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал ;
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэнд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан / аудитын дүгнэлтийн хамт /</li> <li>2. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</li> <li>3. Үнэлэгдсэн үе шатны хуваарь</li> <li>4. Шаардлагатай тусгай зөвшөөрөл</li> </ol> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. УБГ-ний эхээс хийсэн хуулбар /нотариатаар баталгаажуулсан/.</li> <li>2. ААН-ийн товч танилцуулга.</li> <li>3. НӨТ төлөгчийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар.</li> <li>4. Шүүхийн тодорхойлолт</li> <li>5. ШШГА-ны тодорхойлолт</li> <li>6. Татварын тодорхойлолт</li> <li>7. Харьяалагдах Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт</li> <li>8. Харилцагч банкны хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай тодорхойлолт</li> <li>9. Техникийн тодорхойлолт</li> <li>10. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, сертификат / баталгаат орчуулгын газраар орчуулсан/-ыг ирүүлнэ.</li> <li>11. Ажлын төсөв / мэргэшсэн төсөвчингөөр төсвийн программаар хийлгэсэн бүрэн төсөв байна / ирүүлнэ.</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  <b>Төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a></b>  Огноо: <b>2020 оны 9 дугаар сарын 02-ний өдөр</b>  Цаг: <b>09 цаг 00 минут /цахим системээр/</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>“ЭДЦС” ТӨХК,</b>  Давхар болон ерөөний дугаар: <b>4-н давхар, 406 тоот өрөө</b>  Огноо: <b>2020 оны 09 дугаар сарын 02-ний өдөр</b>  Цаг: <b>09 цаг 30 минут /цахим системээр/</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[багцгүй]</b></p>

Дөрөв. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ажлын эзэлхүүн, тоо хэмжээ:

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ-1**

**Зуухан цехийн 0,4 кВ хүчдэлийн БЭН-2 насосын хөдөлгүүрт тавих давтамж хувиргагчийн техникийн тодорхойлолт, суурилуулах ажлын эзэлхүүн**

**1. Давтамж хувиргаагчийн техникийн өгөгдөл**

ТИП МАРК	Оролт, гаралтын параметр		Чадал /кВт/	Тайлбар
<b>ACS580-01-293A-4 (шкафтай) /ABB брэнд/</b>	Input	U1 3~400/480V AC	<b>160 kW</b>	Ашиглалтын заавар нь Англи, Монгол хэл дээр байна.
		I1 293/260A		
		F1 50/60Hz		
	Output	U2 3~0...U1		
		I2 293/260A		
		F2 0...500Hz		

**2. Хийгдэх ажил**

Д/д	Хийгдэх ажил	Тайлбар
1	Удирдлагын хэлхээний схем зураг гаргах	Ерөнхий схем, зарчмын схем, холболтын схем, блокировкийн схем боловсруулах.
2	Демонтаж хийх	Удирдлагын шкафанд
3	Удирдлагын хэлхээний холболт, угсралтыг хийх	Удирдлага, дохиолол, хамгаалалт, блокировкийн хэлхээ
4	Компьютерын удирдлага, хяналт (алсын удирдлага, аналог оролт, гаралт 4-20mA, 0-10V)	Зуухан заалан дахь удирдлагын панелиас залгах, таслах, хурд тохируулах, амперметр харах, тасархай, залгаатай төлвийг харах (улаан, ногоон гэрэл), аварийн кноп, блокировкийн хэлхээг оруулах. Удирдлага, хяналтын кабелийн урт <b>180 метр (18x1,5), зэс, экрантай кабель</b> байна.
5	Хувиргагчийг суурилуулах ( <b>шкаф</b> )	Хуваарилах байгууламжид шкафанд дотор байрлуулж, удирдлагын хэлхээний холболт, угсралтыг хийх, 0,4 кВ хүчдэлийн хүчний кабелийг татаж, төгсгөвч муфьтэн холболт хийх.
6	<b>ACS580-01-293A-4</b> давтамж хувиргагч	Шалгалт, туршилт, тохируулга хийж, ажилд явуулж үзэх.

### 3.Материалын жагсаалт

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Удирдлагын автомат /3А/	ширхэг	1	Удирдлагын хэлхээнд
2	Реле ~220 V 50 Hz	ширхэг	4	
3	Хяналтын гэрэл	ширхэг	3	
4	Удирдлагын кабель КВВГ (18x1,5) зэс, экрантай	метр	180	ХХБ 1СА, 2СА-аас зуухан заалан дахь панель хооронд
5	Хүчний кабель (4x150) 0,4кВ	метр	20	2СА секцийн шкаф №32н-оос давтамж хувиргагч хооронд
6	Холболт, угсралтын кабель гипкий привод (1x1,5)	метр	100	Удирдлагын хэлхээний холболт угсралт хийх
7	Кабель ороогч	метр	100	Удирдлагын хэлхээний холболт угсралт цэгцлэх
8	Наконечник 150	ширхэг	10	Хүчний кабельд
9	Наконечник 50	ширхэг	4	
10	Төгсгөлийн муфьт КНтп-10 150/240	ширхэг	2	ОХУ-ын сайн чанарын муфьт
11	Төгсгөлийн муфьт КНтп-10 150/240	ширхэг	1	Хөдөлгүүрийн кабельд
12	Дундын муфьт ЗСТп-10 150-240	ширхэг	1	
13	Кабель далдлагч	ширхэг	2	Удирдлагын хэлхээний кабелийг далдлах
14	<b>Кабелийн тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу гүйцэтгэнэ.</b>			
15	0-20 mA, 0-10 V хэмжүүр	ширхэг	2	Удирдлагын панель дээр хөдөлгүүрийн эргэлт, гүйдлийг харах
16	Шкаф	ширхэг	1	Давтамж хувиргагчийг суурилуулах
17	Потенциаметр	ширхэг	2	Хурд тохируулах
18	Таслагчийн ир	ширхэг	5	Угсралт
19	Төмрийн шруп	ширхэг	20	
20	Ахуйн газ	ширхэг	3	Муфьт хийхэд
21	Газын хошуу	ширхэг	1	

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ-2

**Зуухан цехийн 0,4 кВ хүчдэлийн БЭН-4 насосын хөдөлгүүрт тавих давтамж хувиргагчийн техникийн тодорхойлолт, суурилуулах ажлын эзэлхүүн**

### 1. Давтамж хувиргагчийн техникийн өгөгдөл

ТИП МАРК	Оролт, гаралтын параметр		Чадал /кВт/	Тайлбар
<b>ACS580-01-430A-4 (шкафтай) /ABB бренд/</b>	Input	U1 3~400/480V AC	<b>250kW</b>	Ашиглалтын заавар нь Англи, Монгол хэл дээр байна.
		I1 430/ A		
		F1 50/60Hz		
	Output	U2 3~0...U1		
		I2 430/ A		
		F2 0...500Hz		

### 2. Хийгдэх ажил

Д/д	Хийгдэх ажил	Тайлбар
1	Удирдлагын хэлхээний схем зураг гаргах	Ерөнхий схем, зарчмын схем, холболтын схем, блокировкийн схем боловсруулах.
2	Демонтаж хийх	Удирдлагын шкафанд
2	Удирдлагын хэлхээний холболт, угсралтыг хийх	Удирдлагын хэлхээний дохиолол, хамгаалалт, блокировка
3	Компьютерын удирдлага, хяналт (алсын удирдлага аналог орлолт, гаралт 4-20mA, 0-10V)	Зуухан заалан дахь удирдлагын панелиас залгах, таслах, хурд тохируулах, амперметр харах, тасархай, залгаатай төлвийг харах (улаан, ногоон гэрэл), аваарийн кноп, блокировкийн хэлхээг оруулах. Удирдлага, хяналтын кабелийн урт <b>180 метр (18x1,5), зэс, экрантай кабель</b> байна.
4	Хувиргагчийг суурилуулах ( <b>шкаф</b> )	Хуваарилах байгууламжид шкафан дотор байрлуулж, удирдлагын хэлхээний холболт, угсралтыг хийх, 0,4 кВ хүчдэлийн хүчний кабелийг татаж, төгсгөвч муфьтэн холболт хийх.
5	<b>ACS580-01-430A-4</b> давтамж хувиргагч	Шалгалт, туршилт, тохируулга хийж, ажилд явуулж үзэх.



### 3. Материалын жагсаалт

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Удирдлагын автомат /3А/	ширхэг	1	Удирдлагын хэлхээнд
2	Реле ~220 V 50 Hz	ширхэг	4	
3	Хяналтын гэрэл	ширхэг	3	
4	Удирдлагын кабель КВВГ (18x1,5) зэс, экрантай	метр	180	ХХБ 3СА-4СА-аас зуухан заал дахь панель хооронд
5	Хүчний кабель 0,4кВ (3x185)	метр	20	4СА секцийн шкаф №58в-ээс давтамж хувиргагч хооронд
6	Хүчний кабель ААШВ-1 3x240	метр	20	Хөдөлгүүр лүү явсан кабельд залгаа хийх
7	Холболт, угсралтын кабель гипкий привод (1x1,5)	метр	100	Удирдлагын хэлхээний холболт, угсралтыг хийх
8	Кабель ороогч	метр	100	Удирдлагын хэлхээний холболт, угсралтыг цэгцлэх
9	Наконечник 185	ширхэг	10	Хүчний кабельд
10	Төгсгөлийн муфьт КНтп 10 150/240	ширхэг	2	ОХУ-ын сайн чанарын муфьт
11	Төгсгөлийн муфьт КНтп 10 150-240	ширхэг	1	ОХУ-ын сайн чанарын муфьт
12	Дундын муфьт ЗСТп-10 150-240	ширхэг	2	Хөдөлгүүрийн кабельд
13	Кабель далдлагч	ширхэг	2	Удирдлагын хэлхээний кабелийг далдлах
14	<b>Кабелийн тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу гүйцэтгэнэ.</b>			
15	0-20 mA, 0-10 V хэмжүүр	ширхэг	2	Удирдлагын панель дээр хөдөлгүүрийн эргэлт, гүйдлийг харах
16	Шкаф	ширхэг	1	Давтамж хувиргагчийг суурилуулах
17	Потенциометр	ширхэг	2	Хурд тохируулах
18	Таслагчийн ир	ширхэг	5	Угсралт
19	Төмрийн шруп	ширхэг	20	
20	Дундын муфьт	ширхэг	1	Хөдөлгүүр лүү явсан кабельд залгаа хийх
21	Ахуйн газ	ширхэг	3	Муфьт хийхэд
22	Газын хошуу	ширхэг	1	

**2.Чанарын шаардлага:** Бараа, сэлбэг материал нь үйлдвэрийн дагалдах баримт бичиг, чанарын сертификаттай, шинэ байх шаардлагатай.

**3.Стандарт:** ОУ-ын стандартын шаардлага хангасан байна.

**4.Баглаа, боодол:** [Нийлүүлэгч барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолын бүрэн бүтэн байдал хариуцах ба холбогдох бусад бичиг баримтыг хүлээлгэж өгнө ]

**5.Бараа хүргэх газар:** “ЭДЦС” ТӨХК-ийн агуулах

### **Зургийн санамж**

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

## **Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

### **Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж**

#### **Зорилт**

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

#### **Ажил-өдрийн хуваарь**

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

#### **Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |  |
|--|--|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                        | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                       | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгааар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгааар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                   | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.  |
| <b>5. Зааварчилгаа</b>                                     | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                             | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                   | <p style="text-align: center;"><b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b></p> <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                        | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.   |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                         | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.   |

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>“БЭН №2, 4 НАСОС ДЭЭР ДАВТАМЖ ХУВЬСГУУР ТАВИХ / 2ш /” ажил гүйцэтгэх.</b>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]-аас бүрдэнэ.</i> Ажлын талбай нь <i>["ЭДЦС"ТӨХК-ийн хашаанд]-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.</i>
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>[Ерөнхий инженер]</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <i>[ 2020.08.16. ]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[ 2020.09.30. ]</i>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[7]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>[12]</i> сар байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[0,1хувь]</i> байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[ажил хүлээлгэн өгөхөөс өмнө ] 7</i> хоногийн дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[ажил хүлээлгэн өгөхөөс өмнө] 7</i> хоногийн дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[үнийн дүнгийн 10%]</i> байна.
	Гүйцэтгэлийн баталгаа: Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай/ \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.



5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]